

## ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН “ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ШАНХАЙН БАЙГУУЛЛАГА” БИЙ БОЛОВ

**Б.БАЛДОО\***

2001 оны 6-р сарын 14-15-нд Хятадын Шанхай хатал “Шанхайн тавын”-Орос, Казакстан, Киргиз, Тажикстан, Хятад улсуудын дээд хэмжээний уулзалт болов. Уг уулзалтад Узбекистан урилгаар оролцов.

Уулзалтад оролцсон улсууд “Хамтын ажиллагааны Шанхайн байгууллага” гэдэг бүс нутгийн шинэ нэгдлийг байгуулав.

1996 оны 4-р сард Орос, Казакстан, Киргиз, Хятад, Тажикстаны удирдагчид Шанхайд уулзаж голлон Хятад ба дөрвөн улсын хоорондох хилийн заагийг тогтоох тухай асуудлыг шийдвэрлэх механизмын маягаар энэхүү нэгдэл анх байгуулагдаж, “Шанхайн тав” гэсэн нэр авсан юм.

Яваандаа энэ нэгдлийн үйл ажиллагаа нэлээдгүй өргөжиж ирэхэд оролцогчид нь түүнээ “Шанхайн форум” гэж нэрлэх болжээ. Өнгөрсөн оны 7-р сард Душанбе хотод болсон форумын ажилд Узбекистан ажиглагчийн эрхтэй оролцсон юм. Өнөө жилийн уулзалтаар таван орны удирдагчдын гарын үсэг зурсан хамтын мэдэгдлээр Узбекистаны оролцоог хууль зүйн үндэстэй болгон бүрдүүлэв. Тэгээд форумын гишүүд тусгай Тунхаглал батлан гаргаж, форуммаа “Хамтын ажиллагааны Шанхай байгууллага” хэмээн тунхаглав.

Бүс нутгийн шинэ байгууллага ийнхүү байгуулж байгаа явдал чухал ач холбогдолтой болох нь маргаангүй. Байгууллагыг үүсгэн байгуулах Тунхаглалд дурьдан зааснаар түүний зорилгууд нь “оролцогч улсуудын хоорондын харилцан итгэлцэл, нөхөрлөл, сайн хөршийн харилцааг бэхжүүлэх, тэдгээрийн хооронд улс төр, худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёл, боловсрол, эрчим хүч, зам тээвэр, экологи болон бусад салбарт үр бүтээлтэй хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих”-д орших ажээ. Эдгээрээс гадна байгууллагад оролцогчид “бүс нутагт (Төв Азид-ред) энх тайван, аюулгүй, тогтвортой байдлыг дэмжин хангахын тулд хамтын хүчин чармайлтаа тавих, олон улсын шинэ ардчилсан, шударга агаад зүй зохистой улс төрийн ба эдийн засгийн дэг журмыг бүтээн байгуулах зориг эрмэлзлэл дүүрэн байгааг илэрхийлсэн байна.

\* Б.Балдоо - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, академич

Тунхаглалд бүс нутгийн шинэ байгууллага нь гурав дахь улсууд, эсвэл бүлэг улсуудын эсрэг хандсан холбоо бишээ гэдгийг онцлон дурдсан байна.

Форумын гишүүн орнууд алан хядах (терроризм), салан тусгаарлах (сепаратизм) болон туйлшран даврах (экстремизм) явдлын бүх илрэлийн эсрэг тэдгээр нь хаанаас иш үндэстэйг үл харгалзан тэмцэх хатуу бодолтой байгаагаа форумын тусгай гэрээ (конвенц)-гээр мэдэгдсэн байна.

Форумын хүрээнд Оросын ерөнхийлөгч В.Путин БНХАУ-ын дарга Цзян Цзэминтэй уулзаж ярилцав. Энэ уулзалтаар хоёр талын хамтын ажиллагааны болон олон улсын тулгам гол асуудлуудыг хэлэлцсэн бөгөөд энэ нь өнөө зун Цзян Цзэмин Москвад айлчлахын өмнөхөн болсноороо онцгой ач холбогдолтой ажээ.

Дурдсанаас үндэслэн Шанхайн форумыг орчин цагийн олон улсын амьдралд тохиож буй нэн чухал үйл явдлуудын нэг боллоо гэж үзэж болно. Тиймээс ч энэ форумын ажлыг дэлхийн улс орнууд анхааралтай ажиг харж байна.

“Хамтын ажиллагааны Шанхайн байгууллага” бүс нутгийн нээлттэй байгууллага бөгөөд хүссэн улс орон түүнд нэгдэн хамтран ажиллах бололцоотой аж. Шанхай форумын цаашид өрнөх үйл ажиллагаа бүс нутаг (Төв Ази) ба бүс нутагт ойролцох улсуудын сонирхлыг татах нь зүйн хэрэг.

Тийм улсын нэг нь Монгол Улс мөн. Бүс нутагтаа итгэлцэл, нөхөрлөл, сайн хөршийн харилцааг бэхжүүлэх; нийгмийн амьдралын улс төр, худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан-технологи гэх мэт салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх; энх тайван, аюулгүй, тогтвортой байдлыг хангах; терроризм, сепаратизм, экстремизмийн эсрэг хамтран тэмцэх явдал Монгол улсын гадаад бодлогын чухал зорилтууд байдаг. Иймээс Төв Азийн орнууд оролцон шинэ тутам байгуулагдаж байгаа хамтын ажиллагааны энэ байгууллага цаашид хэрхэн эмхлэгдэн бүрэлдэж, ямар тодорхой бодлого, үйл ажиллагаа явуулахыг Монгол Улс ширтэн харж, ихээхэн сонирхол хандуулах нь дамжиггүй.

Хамтын ажиллагааны Шанхайн байгууллага үүсч байгаа үйл явцыг Монгол улсыг урагш хөгжүүлэхэд зайлшгүй чухал гадаад эдийн засгийн хамтын ажиллагааны үйлсийг өргөтгөхөд тус дэм үзүүлэх бас нэг олон улсын хүчин зүйл төрөн гарч байна гэж үзэлтэй.